

**"ТЭЭВЭР ДАРХАН" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 02 сарын 16 өдөр

№ 01

Дархан уул аймаг

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

"Тээвэр дархан" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурал 2026 оны 2 сарын 16-ны өдрийн 10⁰⁰ цагт гүйцэтгэх захирлын өрөөнд эхлэв.

Хуралд Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүн Ж.Очирсүх, ердийн гишүүн М.Оюун, Ж.Мөнхтөр, Л.Амарсанаа, М.Жавхлан, Б.Саруул хараат бус гишүүн Д.Бумцэрэн, Д.Чулуун, Х.Жаргалсайхан нар оролцов. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Жавхлантөгс хурлын ирц 100 хувь хуулийн дагуу хүрч байгааг танилцуулав.

Ингээд хурлыг нээж хурал даргалагч ТУЗ-ийн дарга Ж.Очирсүх хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46.5, 46.6 дэх заалт, компанийн дүрмийн 21.1, 21.5 дахь заалтын дагуу ТУЗ ногдол ашиг олгох, эс олгох талаар шийдвэрээ гаргаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх ёстой.

Хурал даргалагч ТУЗ-ийн дарга Ж.Очирсүх: Ингээд компанийн гүйцэтгэх захирал, гишүүн М.Оюун ногдол ашиг олгох, эс олгох талаар мэдээлэл өгнө.

Хувьцаа эзэмшигч М.Оюун: 2025 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулсан захын доторх зам талбайн 2 дугаар хэсгийн ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор ХААН банкнаас 2,7 тэрбумын зээл авч төлөвлөсөн хугацаанд хийж гүйцэтгэсэн. 2026 онд Буян захын орчимд зам засварын ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна. 2025 оны 2 дугаар улиралд түрээсийн төлбөрийг 20% нэмэгдүүлж компанийн орлогыг өсгөснөөр компани ашигтай ажиллаж, нэгж хувьцаанд 500 төгрөгийн ногдол ашиг тараах санал оруулж байна.

Хурал даргалагч Ж.Очирсүх: "Тээвэр Дархан" ХК-ний ерөнхий нягтлан бодогч Д.Бямбажаргал 2025 оны үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн үр дүнгийн талаар тайлангаа танилцуулна.

Хурал даргалагч: Та бүхэн тайлантай танилцлаа. Хэлэлцэж буй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Санал хүсэлт байвал хэлж болно.

ТУЗ-ийн гишүүн Ж.Очирсүх: Миний хувьд дэмжиж байна.

ТУЗ-ийн гишүүн Л.Амарсанаа: Ашгаас хувьцаа эзэмшигчдэд өгөөж хүртээх нь компанийн засаглалын зөв жишиг гэж үзэж байна. Тиймээс санал болгосон хэмжээгээр ногдол ашиг олгохыг дэмжиж байна.

ТУЗ-ийн гишүүн М.Жавхлан: Дэмжиж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Бумцэрэн: Хувьцаа эзэмшигчдийн итгэл, зах зээл дээрх компанийн үнэлгээг хадгалах үүднээс ногдол ашиг тараах нь зүйтэй. Санал болгож буй хэмжээг бодит нөхцөлд нийцсэн гэж үзэж, дэмжиж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Чулуун: Гүйцэтгэх захирлын саналыг дэмжиж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Жаргалсайхан: Саналыг дэмжье.

Хурал даргалагч: Та бүхэнд өөр санал байвал хэлж болно. Байхгүй бол хурлаас доорх тогтоолыг гаргахаар шийдвэрлэж байна.

Та бүхэнд танилцуулья. Үүнд:

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46.5, 46.6 дахь заалт, "Тээвэр дархан" ХК-ийн дүрмийн 21.1, 21.5 дахь заалт, ТУЗ-ийн 2026 оны 2 сарын 16-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцогч гишүүдийн 100 хувийн саналаар нэгж хувьцаанд 500 төгрөг олгох саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.
2. Ногдол ашгийг 2026 оны 12 сарын 31-ны дотор олгох саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.
3. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.

Хурал даргалагч: Та бүхэн хурлаас гарах тогтоолын төсөлтэй танилцлаа. ТУЗ-ийн гишүүд та бүхэнд ажлын амжилт, эрүүл энхийг хүсье. Энэ удаагийн ээлжит хурал өндөрлөж байна.

Тэмдэглэл хөтөлсөн:
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Э.Жавхлантөгс

Шийдвэрийг зөвшөөрсөн:

Хурлын дарга:

Ж.Очирсүх

ТУЗ-ийн гишүүд:

М.Оюун

Ж.Мөнхтөр

Л.Амарсанаа

М.Жавхлан

Б.Саруул

ТУЗ-ийн хараат бус

гишүүд:

Д.Чулуун

Д.Бумцэрэн

Жаргалсайхан